



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

### Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сэргээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Газрын дүрмийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын болон Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаалаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь түдгэлзүүлээд байсан Амури Оргил ХХК-ийн “Гранд хилл” зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү шийдвэрийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.БАТБААТАР

1150500053